



ТАВАНТОЛГОЙ ХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ**  
**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 3 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар...35

Тавантолгой

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ**  
**ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**


Компанийн тухай хуулийн 60.1, 76.1.3 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 14 цагаас Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан овоо баг, Тавантолгой уурхайн тосгон, “Тавантолгой” ХК-ийн хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
  - Компаний 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан,
  - Компаний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт,
  - 2018 оны ногдол ашиг хуваарилалтын тайлан, 2019 оны ногдол ашиг хуваарьлах ТУЗ-ийн шийдвэрийн тухай,
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийг батлах тухай,
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай нийтэд мэдээлэх өдрийг 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай мэдээллийг “Монголын Хөрөнгийн бирж”ХК-ий цахим хуудас болон өдөр тутмын сониноор дамжуулан хүргэхээр журамласугай.
6. Санал авах хуудасны агуулгыг 1 дүгээр хавсралтаар, ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал авах хуудасны агуулгыг 2 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчид танилцах бололцоотой баримт бичгийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
7. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийг энэхүү тогтоолын 6 дугаар зүйлд заасан баримт бичигтэй танилцах бололцоо олгох зохион байгуулалтын арга хэмжээ авахыг гүйцэтгэх захирал Р.Сэддоржид үүрэг болгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар В.Мөнхбатыг, тооллогын комиссын даргаар Ч.Төрмандах, гишүүдээр Л.Нямжав, С.Одонтуяа нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Э.Өлзийжаргалыг, гишүүдээр Д.Дагвадорж, Т.Тэгшээ нарыг тус тус томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулахыг комиссын дарга Э.Өлзийжаргалд үүрэг болгосугай.

ДАРГА



В.МӨНХБАТ



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2020 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн  
35-тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

“Тавантолгой”ХК  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Компаний хурлын танхим,  
2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр, 14.00 цаг,  
Санал хураах арга-Ердийн.  
Та хүснэгтэд бичигдсэн асуудлын талаар өөрийн  
саналыг / + / тэмдгээр тэмдэглэж гарын үсэг зурна уу?

Хувьцаа эзэмшигчийн: эцгийн нэр.....


өөрийн нэр.....

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо.....

№	Санал өгөх асуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан			
2	Компаний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт			
3	2018 оны ногдол ашиг хуваарьлалтын тайлан, 2019 оны ногдол ашиг хуваарьлах ТУЗ-ийн шийдвэрийн тухай			
4	ТУЗ-ийн 2020 оны төсөв батлах тухай			

Гарын үсэг.....

Саналын хуудсыг авах сүүлчийн өдөр – 2020.4.29



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2020 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн  
3.1 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ  
ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОХ  
САНАЛ АВАХ ХУУДАС**

“Таван толгой” ХК

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал,  
Компаний хурлын танхим,  
2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр, 14.00 цаг,  
Санал хураах арга-кумулятив.  
Та санал хураах кумулятив аргын дагуу саналаа өгнө үү.

Хувьцаа эзэмшигчийн Эцгийн нэр.....

Өөрийн нэр.....

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо.....

Саналын тоо: Ердийн гишүүн .....

Хараат бус гишүүн .....

№	ТУЗ-д нэр дэвшигчийн эцгийн нэр, өөрийн нэр	Зөвшөөрсөн	Татгалзсан
	<b>Ердийн гишүүн</b>		
1.			
2.			
3.			
4.			
5.			
6.			
	<b>Хараат бус гишүүн</b>		
7.			
8.			
9.			

Гарын үсэг.....





Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2020 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн  
35 тоот тогтоолын 3 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ  
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Компанийн үйл ажиллагааны тайлан
2. Компанийн санхүүгийн тайлан;
3. Санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв;
5. Кумулятив аргаар санал өгөх заавар, санал өгөх хуудас;
6. Хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл

Дээрх баримт бичгийг 2020 оны 4 дүгээр сарын 13-нд бэлэн болгосон байна.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_